



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2016 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 35

Мандалговь

Хөрөнгө дахин үнэлж худалдах тухай


Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.3 заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 6.3.3 дах заалтуудыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Аймгийн Эрүүл мэндийн газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 9,817,400 /есөн сая найман зуун арван долоо мянга дөрвөн зуу/ төгрөгийн анхны өртөгтэй, элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнээ нөхсөн Дуа 32-56 улсын дугаартай Уаз-31512 маркын автомашины худалдах доод үнийг 1,500,000 /нэг сая таван зуун мянга/ төгрөг болгон худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 07 сарын 18-ны өдрийн “Хөрөнгө данснаас хасах тухай” 50 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтын 31512 маркын автомашины худалдах доод үнийг хүчингүй болгосугай.

3. Дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газрын даргын үүрэг гүйцэтгэгч С.Ууганбаярт үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР